



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 28 өдөр

Дугаар Б/03

Жаргалтхаан сум


Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Баян-Эрдэнэ багийн өндөр настан Гунгаа овогтой Хуяг нь өвчний улмаас нас барсан тул буяны ажилд зориулж 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2.Буцалтгүй тусламжийн 100,000 (нэг зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, Нягтлан бодогч Т.Энхсайхан нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.ГАНБАТ